ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2022/260/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.khuvsgul.audit.mn<br>Мөрөн хот<br>2022 он | Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn<br>Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ<br>Утас: : 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn<br>Аудитор: Л.Мандахнаран<br>Утас: 92118277 Цахим хаяг:Mandakhnaranl@audit.gov.mn<br>Ихэрмөрөн-аудит ХХК-ийн<br>Захирал: Б.Мядагмаа<br>Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com<br>Аудитор Д.Оюундаваа<br>Утас 99389692 Цахим хаяг: Oyunaa_60@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна.

**Агуулга**


1 Аудитын санал дүгнэлт ........ 3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 11

3. Аудитын тайлан ........ 12

3.1 Ерөнхий зүйл ........ 12

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 12

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 13

3.4 Материаллаг байдал ........ 13

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 13

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 14

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 15

3.8 Аудитын гол асуудал ........ 15

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 15

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 16

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 16

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 16

4. Аудитын илрүүлэлт ........ 16

4.1 Залруулсан алдаа ........ 16

**4.2 Төлбөрийн акт** ........ 16

Аудитаар төлбөрийн акт өгөгдөөгүй болно. ........ 16

**4.3 Албан шаардлага** ........ 16

4.4 Зөвлөмж ........ 16

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчидийн хурал |
| БШУЯ | Боловсрол шинжлэх ухааны яам |

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/166
танай ____________ -ны № ____________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААННУУР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ч.ОЮУНБАДАМ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

1720090001 9070605

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 153,841,724.15 | 181,387,179.01 |
| 33 | АВЛАГА | 241,049.00 | 717,837.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 178,049.00 | 717,837.00 |
| 335 | Бусад авлага | 63,000.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 63,000.00 | 00.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 153,600,675.15 | 180,669,342.01 |
| 351 | Түүхий эд материал | 144,648.00 | 2,078,778.00 |
| 35130 | Эм боох материал | 144,648.00 | 2,078,778.00 |
| 354 | Хангамжийн материал | 153,456,027.15 | 178,590,564.01 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,981,200.00 | 2,161,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 70,461,422.72 | 91,731,197.72 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 31,396,940.00 | 21,139,105.90 |
| 35450 | Барилгын засварын материал | 303,000.00 | 303,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 8,491,500.00 | 25,198,790.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 40,821,964.43 | 38,057,270.39 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,491,861,852.92 | 2,886,560,639.01 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,491,861,852.92 | 2,886,560,639.01 |
| 392 | Биет хөрөнгө | 2,361,563,652.92 | 2,755,175,439.01 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,351,878,429.75 | 2,739,119,949.78 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -181,135,449.85 | -234,271,984.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 34,495,310.00 | 36,700,310.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -1,866,034.34 | -10,428,396.38 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 204,783,273.90 | 120,348,296.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -154,781,690.94 | -38,543,296.84 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 148,112,087.17 | 156,900,291.09 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -83,262,106.97 | -59,489,564.84 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 7,383,000.00 | 1,500,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -7,383,000.00 | 00.00 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 00.00 | 00.00 |
| 39217 | Ном | 43,339,834.20 | 43,339,834.20 |
| 393 | Биет бус хөрөнгө | 130,298,200.00 | 131,385,200.00 |
| 39301 | Програм хангамж | 1,287,000.00 | 1,087,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,287,000.00 | 00.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 130,298,200.00 | 130,298,200.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 2,645,703,577.07 | 3,067,947,818.02 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 150,887.00 | 1,082,966.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 150,887.00 | 1,082,966.00 |
| 413 | Өглөг | 150,887.00 | 1,082,966.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 150,887.00 | 301,517.00 |
| 4136 | Бусад өглөг | 00.00 | 781,449.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 781,449.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,645,552,690.07 | 3,066,864,852.02 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,645,552,690.07 | 3,066,864,852.02 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 614,871,262.10 | 614,871,262.10 |
| 51101 | Өмч: - төрийн | 614,871,262.10 | 614,871,262.10 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,476,255,814.54 | 1,941,141,053.18 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,476,255,814.54 | 1,519,828,891.23 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 421,312,161.95 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 554,425,613.43 | 510,852,536.74 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,645,703,577.07 | 3,067,947,818.02 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,216,206,591.43 | 1,604,662,039.25 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 00.00 | 00.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,158,028,191.43 | 1,506,580,573.98 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 45,635,391.43 | 444,464,673.98 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 45,635,391.43 | 444,464,673.98 |
| 1E+06 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 45,635,391.43 | 444,464,673.98 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 1,112,392,800.00 | 1,062,115,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 1,112,392,800.00 | 1,062,115,900.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 58,178,400.00 | 98,081,465.27 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 210,000.00 | 5,330,865.27 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 5,085,865.27 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 210,000.00 | 245,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 57,968,400.00 | 92,750,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 57,968,400.00 | 92,750,600.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,186,945,314.59 | 1,183,349,877.30 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,186,945,314.59 | 1,183,349,877.30 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,086,139,716.59 | 1,130,278,052.70 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 782,593,893.00 | 749,962,498.00 |
| 210101 | Үндсэн цалин | 657,959,193.00 | 583,689,791.85 |
| 210102 | Нэмэгдэл | 57,397,800.00 | 132,765,470.00 |
| 210104 | Урамшуулал | 67,236,900.00 | 33,507,236.15 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 98,958,909.00 | 100,185,169.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 67,941,874.00 | 70,910,428.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,977,081.00 | 7,555,399.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,330,212.00 | 6,014,077.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,525,942.00 | 1,427,752.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,183,800.00 | 14,277,513.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 29,601,720.00 | 70,120,883.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,110,418.00 | 7,772,409.00 |
| 210302 | Түлш, халаалт | 23,301,402.00 | 61,548,424.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 189,900.00 | 800,050.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,199,302.00 | 34,913,287.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 912,900.00 | 1,527,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,645,500.00 | 5,486,520.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,048,900.00 | 475,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,428,052.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,163,950.00 | 10,679,570.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 16,744,897.00 |
| 2105 | Нормативт зардал | 52,903,974.00 | 53,816,058.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,298,780.00 | 3,813,648.00 |
| 210502 | Хоол, хүнс | 50,605,194.00 | 50,002,410.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 00.00 | 10,565,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 10,565,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 611,800.00 | 704,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 611,800.00 | 704,100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,136,000.00 | 4,231,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 636,000.00 | 3,241,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 990,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 105,134,118.59 | 105,779,257.20 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,527,400.00 | 5,533,837.27 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 95,606,718.59 | 100,245,419.93 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 100,805,598.00 | 53,071,824.60 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 14,309,800.00 | 24,462,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 12,912,300.00 | 24,462,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,397,500.00 | 00.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 79,390,316.00 | 5,504,224.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 79,390,316.00 | 5,504,224.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 7,105,482.00 | 23,105,000.60 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,105,482.00 | 23,105,000.60 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 29,261,276.84 | 421,312,161.95 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | 00.00 | 00.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 29,261,276.84 | 421,312,161.95 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 614,871,262.10 | 554,425,613.43 | 1,446,994,537.70 | 2,616,291,413.23 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -41,781,978.62 | -41,781,978.62 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 614,871,262.10 | 554,425,613.43 | 1,405,212,559.08 | 2,574,509,434.61 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 29,261,276.84 | 29,261,276.84 |
| 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 614,871,262.10 | 554,425,613.43 | 1,476,255,814.54 | 2,645,552,690.07 |
| 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 614,871,262.10 | 554,425,613.43 | 1,476,255,814.54 | 2,645,552,690.07 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 43,573,076.69 | 43,573,076.69 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 614,871,262.10 | 554,425,613.43 | 1,519,828,891.23 | 2,689,125,766.76 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -43,573,076.69 | 00.00 | -43,573,076.69 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 421,312,161.95 | 421,312,161.95 |
| 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 614,871,262.10 | 510,852,536.74 | 1,941,141,053.18 | 3,066,864,852.02 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,171,021,200.00 | 1,160,277,246.27 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,112,392,800.00 | 1,062,115,900.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 1,112,392,800.00 | 1,062,115,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 1,112,392,800.00 | 1,062,115,900.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 58,628,400.00 | 98,161,346.27 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 660,000.00 | 5,330,865.27 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 5,085,865.27 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 660,000.00 | 245,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 57,968,400.00 | 92,750,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 57,968,400.00 | 92,750,600.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 00.00 | 79,881.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 79,881.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,145,841,936.00 | 1,104,112,246.27 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,145,841,936.00 | 1,104,112,246.27 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,045,036,338.00 | 1,050,960,540.67 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 782,239,047.00 | 749,570,207.00 |
| 210101 | Үндсэн цалин | 657,604,347.00 | 583,297,500.85 |
| 210102 | Нэмэгдэл | 57,397,800.00 | 132,765,470.00 |
| 210104 | Урамшуулал | 67,236,900.00 | 33,507,236.15 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 98,958,909.00 | 100,185,169.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 67,408,724.00 | 69,905,510.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,887,621.00 | 7,484,888.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,310,037.00 | 6,363,217.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,577,485.00 | 1,493,414.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,775,042.00 | 14,938,140.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 50,862,918.00 | 59,799,999.40 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,173,418.00 | 7,709,409.00 |
| 210302 | Түлш, халаалт | 44,499,600.00 | 51,290,590.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 189,900.00 | 800,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 19,766,280.00 | 44,735,578.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,038,900.00 | 1,531,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,887,100.00 | 5,202,270.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,048,900.00 | 465,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 77,300.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,620,280.00 | 750,178.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,093,800.00 | 36,785,730.00 |
| 2105 | Нормативт зардал | 78,451,384.00 | 75,845,300.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,487,500.00 | 5,528,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 49,994,684.00 | 66,709,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 25,969,200.00 | 3,607,200.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,910,000.00 | 9,845,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,910,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 9,845,600.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 658,300.00 | 704,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 658,300.00 | 704,100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,266,500.00 | 4,862,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 766,500.00 | 3,872,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 990,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,923,000.00 | 5,412,287.27 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,923,000.00 | 5,412,287.27 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 100,805,598.00 | 53,151,705.60 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 14,309,800.00 | 24,542,481.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 79,881.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 12,912,300.00 | 24,462,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,397,500.00 | 00.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 79,390,316.00 | 5,504,224.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 79,390,316.00 | 5,504,224.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 7,105,482.00 | 23,105,000.60 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,105,482.00 | 23,105,000.60 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 25,179,264.00 | 56,165,000.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 25,179,264.00 | 56,165,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 25,179,264.00 | 56,165,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 25,179,264.00 | 56,165,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 25,179,264.00 | 56,165,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -25,179,264.00 | -56,165,000.00 |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | 00.00 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | 00.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,154,866,500.00 | 1,126,257,275.40 | -28,609,224.60 | 98 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,154,866,500.00 | 1,126,257,275.40 | -28,609,224.60 | 98 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,128,882,600.00 | 1,101,794,675.40 | -27,087,924.60 | 98 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 752,192,100.00 | 749,570,207.00 | -2,621,893.00 | 100 |
| 210101 | Үндсэн цалин | 550,984,200.00 | 583,297,500.85 | 32,313,300.85 | 106 |
| 210102 | Нэмэгдэл | 154,447,900.00 | 132,765,470.00 | -21,682,430.00 | 86 |
| 210104 | Урамшуулал | 46,760,000.00 | 33,507,236.15 | -13,252,763.85 | 72 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 101,546,200.00 | 100,185,169.00 | -1,361,031.00 | 99 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 71,458,300.00 | 69,905,510.00 | -1,552,790.00 | 98 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,522,000.00 | 7,484,888.00 | -37,112.00 | 100 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,017,600.00 | 6,363,217.00 | 345,617.00 | 106 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,504,400.00 | 1,493,414.00 | -10,986.00 | 99 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,043,900.00 | 14,938,140.00 | -105,760.00 | 99 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 72,300,000.00 | 59,799,999.40 | -12,500,000.60 | 83 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,000,000.00 | 7,709,409.00 | -290,591.00 | 96 |
| 210302 | Түлш, халаалт | 63,500,000.00 | 51,290,590.40 | -12,209,409.60 | 81 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 800,000.00 | 800,000.00 | 0.00 | 100 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 46,856,800.00 | 46,856,800.00 | 0.00 | 100 |
| 210401 | Бичиг хэрэг | 719,500.00 | 1,286,900.00 | 567,400.00 | 179 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,000,000.00 | 5,872,270.00 | 872,270.00 | 117 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 469,500.00 | 465,500.00 | -4,000.00 | 99 |
| 210404 | Ном, хэвлэл | 391,300.00 | 00.00 | -391,300.00 | 0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 493,000.00 | 246,400.00 | -246,600.00 | 50 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 39,783,500.00 | 38,985,730.00 | -797,770.00 | 98 |
| 2105 | Нормативт зардал | 75,845,300.00 | 75,845,300.00 | 0.00 | 100 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,528,400.00 | 5,528,400.00 | 0.00 | 100 |
| 210502 | Хоол, хүнс | 66,709,700.00 | 66,709,700.00 | 0.00 | 100 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,607,200.00 | 3,607,200.00 | 0.00 | 100 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 69,050,600.00 | 58,445,600.00 | -10,605,000.00 | 85 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 19,500,000.00 | 19,500,000.00 | 0.00 | 100 |
| 210602 | Тавилга | 29,100,000.00 | 29,100,000.00 | 0.00 | 100 |
| 210604 | Урсгал засвар | 20,450,600.00 | 9,845,600.00 | -10,605,000.00 | 48 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 704,100.00 | 704,100.00 | 0.00 | 100 |
| 210702 | Дотоод албан томилолт | 704,100.00 | 704,100.00 | 0.00 | 100 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,257,300.00 | 5,257,300.00 | 0.00 | 100 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,267,300.00 | 4,267,300.00 | 0.00 | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 990,000.00 | 990,000.00 | 0.00 | 100 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5130200.00 | 5130200.00 | 0.00 | 100 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,130,200.00 | 5,130,200.00 | 0.00 | 100 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 25,983,900.00 | 24,462,600.00 | -1,521,300.00 | 94 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 25,983,900.00 | 24,462,600.00 | -1,521,300.00 | 94 |
| 224001 | Стратегийн нөөц хөрөнгө | 00.00 | 00.00 | 0.00 | |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,154,866,500.00 | 1,126,257,275.40 | -28,609,224.60 | 98 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,062,115,900.00 | 1,056,611,676.00 | -5,504,224.00 | 99 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,062,115,900.00 | 1,056,611,676.00 | -5,504,224.00 | |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 92,750,600.00 | 69,645,599.40 | -23,105,000.60 | 75 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 92,750,600.00 | 69,645,599.40 | -23,105,000.60 | 75 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 | 0.00 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 | 0.00 | |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 67.00 | 67.00 | 0.00 | 100 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 37.00 | 37.00 | 0.00 | 100 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 25.00 | 25.00 | 0.00 | 100 |
| 620004 | Гэрээт ажилтан | 04.00 | 04.00 | 0.00 | 100 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ Төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 5,330,865.27 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,330,865.27 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 5,330,865.27 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 748,778.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 245,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 503,778.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,300,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,300,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 282087.27 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 282,087.27 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 5330865.27 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 5,330,865.27 |

| | | |
|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,085,865.27 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 245,000.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээд Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуульд дотуур байрны хүүхдийн хоолны зардалтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ихэр-мөрөн аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Мядагмаа чанарын хяналтыг хэрэгжүүлж , аудитор Д.Оюундаваа нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихэрмөрөн аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 06 дугаар албан бичгээр Ихэрмөрөн –аудит ХХК-д 01 дүгээр сарын 25-нд ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Зорилго: “Сургалтын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйлд эцэг эх асран хамгаалагчийн оролцоог нэмэгдүүлэн хосолсон сургалтын хэлбэрээр бие даан суралцах арга барил эзэмшүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд 6 зорилт дэвшүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Монгол Улсын засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43-р тогтоол
- Монгол улсын засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 11-ны өдрийн “Үдийн хоолны норматив тогтоох тухай” 237 дугаар тогтоол
- "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал

- Боловсрол шинжлэх ухааны сайд ,Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 01-ны А/35,А/10/9 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн багш,зарим ажиллагсадад олгох ур чадварын шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлах тухай " тогтоол
- Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 5 дугаар сарын 21-ны А/190 дугаар тушаалаар баталсан сурлагын хоцрогдол арилгах тухай

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны 10 дугаар сарын 14-нээс 21-ний хооронд Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар дунд эрсдэлтэй гэж үнэлсэн байна. Шалгалтаар 8 зөвлөмж, 1 актаар хүүхдийн хоолны зардалтай холбоотой 0.6 сая төгрөгийн акт тогтоосон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1,185.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 23.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 18.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургууль 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 157.7 сая төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

*Хүснэгт 1* /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | - |
| Авлага | 0.17 | 0,71 | 0.54 |
| Бараа материал | 153.6 | 180.7 | 27.1 |
| Үндсэн хөрөнгө | 2,491.8 | 2,886.5 | 394 |
| **Нийт хөрөнгө** | 2,645.7 | 3,067.9 | 422.2 |
| Өр төлбөр | 150.0 | 1,082,9 | 932.1 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,645.5 | 3,066.8 | 421.3 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 2,645.7 | 3,067.9 | 422.2 |

Тайлант онд цалинтай холбоотой 0.7 сая төгрөгийн авлага, 1.0 сая төгрөгийн өглөг үүссэн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 180.7 сая болж 27.1 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 21.3 сая төгрөг, хүнсний материал 16.7 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,886.5 сая төгрөг болж 394.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь үндсэн хөрөнгө дансанд БШУЯ-наас 17.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж 3.7 сая төгрөгийн ном, тус тус үнэ төлбөргүй авч,Хөвсгөл аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 06 дугаар сарын 25-ний 71 дугаар тогтоолын дагуу· Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дотуур байрны сайжруулалт хийгдсэн 398.2 сая төгрөгийг барилга дансанд нэмсэн байгаа нь нөлөөлжээ.

Цагааннуур сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/68 дугаар тогтоол, 12 дугаар сарын 17-ны өдрийн А/26 дугаар тогтоолоор 186 нэрийн 98.6 сая төгрөгийн элэгдлээрээ өртгөө нөхсөн ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгө акталсан байна. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны 111 дүгээр тогтоолоор элэгдлээрээ өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 75 нэрийн 21.4 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж орлого авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,066.8 сая төгрөг болж 421.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нөлөөлжээ.

Нийт зардал өмнөх оноос 3.6 сая төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан байна.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны төсөв 1,112.8 сая төгрөгөөр батлагдсан ба Хөвсгөл аймгийн засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 28-ны А/281 дүгээр захирамж, Хөвсгөл ИТХ-ын 08 дугаар сарын 20-ны 01 дүгээр тогтоолоор 42.0 сая төгрөгийн хасах тодотгол хийгдэж, Аймгийн засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны А/608 захирамжаар зохицуулалт хийгдэж оны эцэст 1,154.8 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

**3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тус сургууль нь тусгай шилжүүлгийн санхүүжилтээс 1,062.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 92.7 сая төгрөгийн бүгд 1,154.8 сая төгрөгийн санхүүжилтийн орлогоос 1,126.2 төгрөгийг зарцуулж 28.6 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2 сая төгрөгөөр

| № | Хөтөлбөр, арга хэмжээний нэр | Санхүүжилтийн дүн | |
|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | 71802 Ерөнхий боловсрол | 1,139.8 | 1,110.9 |
| 2 | 71806 Насан туршийн боловсрол | 15.3 | 15.3 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Боловсролын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 06-ны А/45 дугаар тушаалаар Боловсролын чанарын шинэчлэл төслийн санхүүжилт 4.3 сая төгрөг, Аймгийн Боловсролын газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар суралцагчдын мэдлэг чадварын ялгаатай байдлыг оношлох үнэлгээний шалгалтын бичиг хэргийн зардал 0.3 сая төгрөг, Боловсролын газрын даргын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны А/40 дүгээр тушаалаар ариутгалын зардал 0.5 сая төгрөг болон тендерийн бичиг баримтын 0.2 сая төгрөг бүгд 5.3 сая төгрөг нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрч зарцуулагдсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Монгол Улсын ерөнхий аудиторын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу төсвийн хэмнэлтийн бодлого, зарцуулалт, шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад асуудалд анхаарлаа хандуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад АОУС 701.8-д тодорхойлсон үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь 5 сая төгрөгөөс дээш 18 худалдан авалтын 251.1 сая төгрөг, орлогын 1,155.0 сая төгрөг, зарлагын 18 гүйлгээний 197.0 сая төгрөгийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн данс цахим хуудсанд мэдээлвэл зохих холбогдох мэдээллийг 98 хувьтай мэдээлсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн 1 мэдээ хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар Шилэн данс, биет бус хөрөнгө, түлээний зардалтай холбоотой 4 зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт-4* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 1.1 | 1 | 1.1 | - | - | 100.0 |
| **Нийт дүн** | 1 | 1.1 | 1 | 1.1 | - | - | 100.0 |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй болно.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт өгөгдөөгүй болно.

### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

*1.1. Илрүүлэлт:*

Хүүхдийн хоолны зардлыг түүвэрлэн шалгахад 2021 онд дотуур байрны хүүхдийн хоолонд 50.0 сая төгрөгийн хүнсний материал зарцуулсаныг нийт хоолны цэсний 13304 хүүхэд өдөрт харьцуулахад 1 өдрийн дундаж зардал 3758 төгрөг болж нормативаас 283 төгрөг, нийт 3.7 сая төгрөгөөр хэтэрсэн байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

***1.2.*** *Өгсөн зөвлөмж*

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор баталсан дотуур байрны хүүхдийн нэг хоногийн хоолны зардлын нормативыг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | 1 | 3.7 | - | - | - | | - | | 1 | 3.7 |

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС

ДАРГА ,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Э.БАТ-ЭРДЭНЭ Огноо II/25

АУДИТОР Л.МАНДАХНАРАН Огноо: II/24

ИХЭРМӨРӨН АУДИТ-ХХК

ХЯНАСАН:ЗАХИРАЛ, АХЛАХ АУДИТОР Б.МЯДАГМАА Огноо

АУДИТОР Д.ОЮУНДАВАА Огноо